



МОНГОЛ УЛС
ТӨВ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 05 сарын 07 өдөр

Дугаар А/300

Зуунмод

Өндөржүүлсэн бэлэн байдлын
зэрэгт ажиллах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 “а”, “ж”, “л”, 29.2, 30 дугаар зүйлийн 30.1.6, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.2, 10.4, 11 дүгээр зүйлийн 11.2, 11.3.3, 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.8, Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 115, 118 дугаар тогтоол, Улсын Онцгой Комиссын даргын 2021 оны 41, 42 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Засгийн газрын 2021 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн 115 дугаар тогтоолоор “Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт” шилжүүлсэнтэй холбогдуулан аймгийн хэмжээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлсүгэй.

1.1. Аймгийн хэмжээнд “Бүх нийтийн бэлэн байдлын зэрэг”-ийн үед үйл ажиллагаа нь хязгаарлагдсан аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааг Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 118 дугаар тогтоолын дагуу “Улбар шар түвшинд” зохицуулан үе шаттай нээж, халдвар хамгааллын дэглэм, үйлчлэх цагийн хязгаарыг Улсын Онцгой комиссын даргын 2021 оны 41 дүгээр тушаалаар баталсан түр журмын хүрээнд орон нутгийнхаа нөхцөл байдалд зохицуулан шийдвэрлэж ажиллуулахыг сумдын Засаг дарга нарт даалгасугай.

1.2. Аж ахуйн нэгж, байгууллагууд үйл ажиллагаа эхлэхийн өмнө болон явцын халдвар хамгааллын дэглэм, бусад зохион байгуулалтын арга хэмжээний бэлтгэл ажлыг хангуулж хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн хяналтын газар (У.Өлзийцэцэг)-т үүрэг болгосугай.

1.3. Сумдад Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын улмаас үүссэн нөхцөл байдалд шат дараалсан шуурхай хариу арга хэмжээ авч ажиллахыг Онцгой байдлын газрын дарга бөгөөд аймгийн Онцгой комиссын орлогч (Н.Төмөрбаатар)-т үүрэг болгосугай.

1.4. Согтууруулах ундааг худалдан борлуулах асуудлыг шийдвэрлэхдээ сум орон нутгийнхаа нөхцөл байдалд тохируулан зохицуулж шийдвэр гаргахыг сумын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

2. Хот хооронд болон орон нутагт зорчих иргэдийн хөдөлгөөнийг Улсын Онцгой комиссын даргын 2021 оны 42 дугаар тушаалаар батлагдсан “Хот болон орон нутаг хооронд зорчих иргэдийн хөдөлгөөнийг зохицуулах түр журам”-ын 2 дахь хэсгийг үндэслэн зохион байгуулалтын арга хэмжээг авч ажиллахыг Онцгой байдлын газар (Н.Төмөрбаатар), Төв аймаг дахь Цагдаагийн газар (Б.Ганзориг) нарт тус тус даалгасугай.

3. Энэ захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2021 оны А/274 дүгээр захирамжийг хүчингүй болсонд тооцугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Онцгой байдлын газрын дарга бөгөөд аймгийн Онцгой комиссын орлогч (Н.Төмөрбаатар)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Д.МӨНХБААТАР